

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын үнэт цаасны клирингийн төвийн 2025 оны хаалтын санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **САГ-2026/52/НА-СТА-ТӨҮГ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: <a href="mailto:chantsaldulamp@audit.gov.mn">chantsaldulamp@audit.gov.mn</a> Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51-261740 Цахим хаяг: <a href="mailto:tegshsurenb@audit.gov.mn">tegshsurenb@audit.gov.mn</a> Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг Утас: 70169029 хаяг: <a href="mailto:info@misheelodaudit.mn">info@misheelodaudit.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал .....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/715  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН  
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ЭНХСАЙХАН  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хаалтын санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хаалтын санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолоор Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д нэгтгэх шийдвэр гарч 2025 оны 12 сарын 31-ний байдлаар нэгтгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар 17-ны өдрийн 748 дугаар тогтоолоор 207.6 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг балансас баланст шилжүүлэхээр тусгасан боловч жилийн эцсийн санхүүгийн тайланд 26.5 сая төгрөгийн

хорогдол болон 4.4 сая төгрөгийн элэгдлийн зардлын дүн тусгагдаж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд 176.7 сая төгрөгөөр хүлээлгэн өгсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөр дуусгавар болсон хаалтын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 12-р сарын 31	2026 оны 01-р сарын 08
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,767,274.05	-
1.1.4	Бусад авлага	92,208,696.39	-
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>96,975,970.44</b>	-
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>96,975,970.44</b>	-
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.3	Татварын өр	852,808.26	-
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>852,808.26</b>	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>852,808.26</b>	-
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	-	-
2.3.1	Өмч:-төрийн	-	-
2.3.2	- хувийн	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	96,123,162.18	-
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>96,123,162.18</b>	-
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>96,975,970.44</b>	-

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөр дуусгавар болсон хаалтын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>804,812,477.87</b>	-
2	Борлуулалтын өртөг	-	-
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>804,812,477.87</b>	-
5	Хүүгийн орлого	141,717,530.85	-
8	Бусад орлого	62,217,490.29	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,137,443,737.83	25,900.94
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	45,017.57	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	(6,743,883.14)	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(135,395,104.39)</b>	<b>(25,900.94)</b>
19	Орлогын татварын зардал	14,171,753.08	-
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(149,566,857.47)</b>	<b>(25,900.94)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(149,566,857.47)</b>	<b>(25,900.94)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(149,566,857.47)</b>	<b>(25,900.94)</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Монголын үнэт цаасны клирингийн төвийн 2025 оны хаалтын санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөр дуусгавар болсон хаалтын тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>23,781,409.08</b>	<b>470,797,343.22</b>	<b>825,795,626.89</b>	<b>3,320,374.399.94</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>23,781,409.08</b>	<b>470,797,343.22</b>	<b>825,795,626.89</b>	<b>3,320,374.399.94</b>
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	(149,566,857.47)	(149,566,857.47)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	(2,000,000,020.75)	-	(470,797,343.22)	(496,815,598.61)	(2,967,612,962.58)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(83,414,675.00)	(83,414,675.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(23,781,409.08)	-	-	(23,781,409.08)
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	-	<b>(95,998,495.81)</b>	<b>(95,998,495.81)</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	977,474.63	977,474.63
<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-	<b>96,975,970.44</b>	<b>96,975,970.44</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(96,950,069.50)	(96,950,069.50)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(25,900.94)	(25,900.94)
<b>2026 оны 01-р сарын 08-ны үлдэгдэл</b>	-	-	-	-	-

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөр дуусгавар болсон хаалтын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны 12 сарын 31	2026 оны 01 сарын 08
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>251,790,570,670.12</b>	-
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	755,052,226.34	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	251,035,518,443.78	-
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>254,938,261,053.37</b>	<b>25,900.94</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	535,612,702.91	-
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	145,036,976.11	-
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,068,060.00	-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	97,149,693.59	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	49,124,580.51	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	254,109,269,040.25	25,900.94
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,147,690,383.25)</b>	<b>(25,900.94)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>224,296,336.63</b>	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	6,000.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	224,290,336.63	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>9,112,700.00</b>	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,112,700.00	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>215,183,636.63</b>	-
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,889,648,306.16</b>	<b>4,741,373.11</b>
3.2.4	Төлөгдсөн ногдол ашиг	83,414,675.00	-
3.2.5	Балансаас баланс-д шилжүүлсэн	2,806,233,631.16	4,741,373.11
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,889,648,306.16)</b>	<b>(4,741,373.11)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>12,531,706.15</b>	-
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(5,809,623,346.63)</b>	<b>(4,767,274.05)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,814,390,620.68</b>	<b>4,767,274.05</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,767,274.05</b>	-

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>									
1	Үнэт цаасны клирингийн шимтгэл орлого	м.төг	890,402.0	1,097,000.0	766,812.5	(123,589.5)	86.1	(330,187.5)	69.9
	Гишүүний хураамжийн орлого	м.төг	36,000.0	38,000.0	38,000.0	2,000.0	105.6	-	100.0
	Хүүний орлого	м.төг	184,590.0	226,208.0	204,867.7	20,277.7	111.0	(21,340.3)	90.6
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>1,110,992.0</b>	<b>1,361,208.0</b>	<b>1,009,680.2</b>	<b>(101,311.9)</b>	<b>90.9</b>	<b>(351,527.9)</b>	<b>74.2</b>
3	Нийт зардал	м.төг	945,881.0	1,318,166.0	1,145,077.7	199,196.7	121.1	(173,088.3)	86.9
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	945,881.0	1,318,166.0	1,145,077.7	199,196.7	121.1	(173,088.3)	86.9
4	Татварын өмнөх ашиг	м.төг	165,111.0	43,042.0	(135,397.5)	(300,508.5)	(82.0)	(178,439.5)	(314.6)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	146,652.0	20,421.0	(149,569.3)	(296,221.3)	(102.0)	(169,990.3)	(732.4)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	133,533.9	22,621.0	143,255.4	9,721.4	107.3	120,634.4	633.3
	а/ Орлогын татварт	м.төг	18,459.0	22,621.0	14,171.8	(4,287.3)	76.8	(8,449.3)	62.6
	в/ НДШ	м.төг	68,014.0	-	75,543.9	7,529.9	111.1	75,543.9	
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	47,060.9	-	53,539.7	6,478.8	113.8	53,539.7	
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	20,000.0	83,414.7	83,414.7		63,414.7	417.1
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	17.0	18.0	11.0	(6.0)	64.7	(7.0)	61.1
9	Нийт цалингийн сан	м.төг	524,422.0	742,242.0	697,767.2	173,345.2	133.1	(44,474.8)	94.0
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	30,848.4	41,235.7	63,433.4	32,585.0	205.6	22,197.7	153.8
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.9	1.0	1.3	0.5	155.3	0.4	136.1
12	Хөрөнгө оруулалт	м.төг	2,348.0	331,940.0	9,112.7	6,764.7	388.1	(322,827.3)	2.7
<b>13</b>	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>58,282.9</b>	<b>-</b>	<b>92,208.7</b>	<b>33,925.8</b>	<b>158.2</b>	<b>92,208.7</b>	
14	Нийт өглөг	м.төг	2,811,033.8	-	977.5	(2,810,056.3)	0.0	977.5	
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	2,800,781.0	-	977.5	(2,799,803.5)	0.0	977.5	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	10,252.8	-	-	(10,252.8)	0.0	-	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Компани, түүний үйл ажиллагаа**

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь 2016 оны 4 дүгээр сард үнэт цаасны арилжааны дүнд үүссэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх, арилжаанд оролцогчдын үнэт цаас болон мөнгөн төлбөр тооцоо гүйцэтгэх чиг үүрэгтэйгээр “Арилжааны төлбөр тооцоо” ХХК нэртэйгээр байгуулагдсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 29 дүгээр тогтоолоор хөрөнгийн зах зээлд үнэт цаасны дараа төлбөрт тооцоо, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний дотор нэвтрүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотой компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орж клирингийн үйл ажиллагааг гүйцэтгэх болсон. Үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүргээс хамааруулан “Монголын үнэт цаасны клирингийн төв” болсон.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн эрхэм зорилго нь үнэт цаасны клирингийн үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу зохистой гүйцэтгэж, хөрөнгийн зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжин чиглүүлж ажиллахад оршино.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь эрхэм зорилгоо үнэт цаасны болон мөнгөн төлбөрийн үүргийг гэрээ тус бүрээр болон нэгдсэн дүнгээр тодорхойлох клирингийн үндсэн үйл ажиллагаа, тэрхүү төлбөрийн үүрэг бүрэн биелэгдэхтэй холбоотой болзошгүй эрсдэлийг удирдах үндсэн үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу зохистой гүйцэтгэж, хөрөнгийн зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжин чиглүүлж ажилласан байна.

#### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Тус компани нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын тухай хууль, Үнэт цаасны клирингийн журам, Төлбөрийн баталгааны сангийн хуримтлал тооцох журам, Төлбөрийн баталгааны сангийн зөвлөлийн ажиллах журам, Үүсмэл санхүүгийн хэрэгслийн клирингийн журам, Төлбөрийн баталгааны сангийн зөвлөлийн ажиллах, тооцох журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байсан.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус компани нь дотоод хяналтын албагүй, дотоод хяналтын нэг ажилтантай, тайлант онд 7 үндсэн ажлын хүрээнд 19 ажил хэрэгжүүлэхээс гүйцэтгэл 80 хувьтай ажилласан байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь 2025 оны хаалтын санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2025 оны хаалтын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,009.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	5,814,390.6	-	(5,814,390.6)
Авлага	60,650.8	-	(60,650.8)
Бараа материал	5,142.1	-	(5,142.1)
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	17,632.1	-	(17,632.1)
Эргэлтийн бус хөрөнгө	233,592.7	-	(233,592.7)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>6,131,408.3</b>	-	<b>(6,131,408.3)</b>
Өр төлбөр	2,811,033.9	-	(2,811,033.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,320,374.4	-	(3,320,374.4)
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>6,131,408.3</b>	-	<b>(6,131,408.3)</b>

/мянган төгрөгөөр/

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,814.4 сая төгрөгөөр буурсан нь клирингийн шимтгэлийн болон хүүгийн орлого 985.4 сая төгрөг, бусад 251,035.5 сая төгрөг орж, тайлант оны урсгал зардалтай холбоотой 836.4 сая төгрөгийн зардал гарч, Санхүүгийн зохицуулах хороонд арилжааны шимтгэлийн зардал 83.4 сая төгрөг, Монгол банканд байршилтай үнэт цаасны компаниудын барьцаа хөрөнгө 254,109.3 сая төгрөг, Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 228 дугаар тушаалын дагуу 2,806.2 сая төгрөгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д тус тус шилжүүлсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 60.6 сая төгрөгөөр буурсан нь клирингийн үйл ажиллагаатай холбоотой 88.8 сая төгрөгөөр өсөж, хүүгийн авлага 24.5 сая төгрөгөөр буурч, Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 228 дугаар тушаалын дагуу 125.0 сая төгрөгийн авлагыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д шилжүүлсэн.

Бараа материал дансны үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр буурсан нь 2.9 сая төгрөгийн үлдэгдлийг үйл ажиллагаанд зарцуулж, 2.2 сая төгрөгийн бараа материалыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д шилжүүлсэн.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 17.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд зардлаар хүлэн зөвшөөрч бүртгэсэн.

Эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэл 233.6 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 748 дугаар тогтоолын дагуу 203.2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, 36.8 сая төгрөгийн хөрөнгийг акталсан.

Өр төлбөр данс 2,811.0 сая төгрөгөөр буурсан нь хойшлогдсон татварын өглөг 10.2 сая төгрөг, клирингийн үйл ажиллагаатай холбоотой барьцаа хөрөнгийн өглөг 2,575.3 сая төгрөг, төлбөрийн баталгааны өглөг 96.2 төгрөг, арилжаанд оролцогчдод өгөх өглөг 129.3 сая төгрөгөөр тус тус буурч, тайлант оны хувь хүүний орлогын албан татварын 26.3 сая төгрөгийн өглөгийг Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 228 дугаар тушаалын дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д тус тус шилжүүлсэн.

Засгийн газрын хувь оролцоо данс 3,320.4 сая төгрөгөөр буурсан нь Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 228 дугаар тушаалын дагуу 2,000.0 сая төгрөгийн төрийн өмч болон 470.8 сая төгрөгийн эрсдэлийн санг тус тус шилжүүлж, 23.8 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулж, хуримтлагдсан үр дүн 825.8 сая төгрөгөөр буурсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь ТУЗ-ийн 2024 оны 28 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр нийт орлогыг 1,361.2 сая төгрөг, нийт зарлагыг 1,318.2 сая төгрөг, 43.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 331.9 сая төгрөг зарцуулахаар баталсан.

### ***Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин***

Тайлант онд нийт 1,361.2 сая төгрөгийн орлого олж, 1,318.2 сая төгрөгийн зардал гарган 43.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1,009.7 сая төгрөгийн орлого олж, 1,145.1 сая төгрөгийн зардал гарган татварын дараах байдлаар 135.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь уул уурхайн биржээс орлого орохоор төлөвлөсөн боловч хэрэгжээгүй, үнэт цаасны зах зээлийн биржийн арилжаа тайлант онд идэвхтэй явагдаагүйгээс орлого буурсантай холбоотой байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хаалтын санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн аудитын компани нь, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, захирал Т.Одончимэг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Тэгшсүрэн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Мишээл-Од Аудит ХХК-д 2026 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн 01/205 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,135.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 11.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэх зэрэг арга хэмжээ авч 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан ба хэтэрсэн зардал байхгүй, компани татан буугдах шийдвэртэй холбоотойгоор 7 сараас хойш ажиллагсад ажлаас гарснаас цалингийн зардал хэмнэгдсэн.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3-р улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлангийн бүх дансуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр 366.4 сая төгрөгийн 6 асуудлыг залруулах, ажил сайжруулахаар Монголын үнэт цаасны

Монголын үнэт цаасны клирингийн төвийн 2025 оны хаалтын санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

клирингийн төв ХХК-ийн удирдлагад өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажлын хэсэг томилон ажиллаж 366.4 сая төгрөгийн 6 асуудлыг бүрэн засаж, залруулсан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	6,253.8	2	6,253.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>6,253.8</b>	<b>2</b>	<b>6,253.8</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай “ 61 дүгээр тогтоолоор Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д нэгтгэх шийдвэр гарч 2025 оны 12 сарын 31-ний байдлаар нэгтгэсэн байна. Иймд дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Жилийн эцсийн хаалтын санхүүгийн тайланд аудит хийхэд алдаа илрээгүй болно.